



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 11 өдөр

Дугаар 116235

Улаанбаатар хот

**Хан-Уул дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын балансаас хөрөнгө  
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 29,201,590 (хорин есөн сая хоёр зуун нэг мянга таван зуун ер) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хан-Уул дүүргийн харьяа хэлтэс, газрын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар (С.Энхбаяр)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг хавсралтад заасан дүүргийн харьяа газар, хэлтсийн удирдлагуудад даалгасугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар (С.Энхбаяр)-т, тус дүүргийн харьяа газар, хэлтсийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА



13	Dell optiMex I3 суурин компьютер	2019.09.18	ш	1	1,295,800	1,295,800.00	161,978.00	1,133,822.00	ХУД-ын Албан бус насан туршийн боловсрол
14	Dell optiMex I3 суурин компьютер	2019.09.18	ш	2	1,295,800	2,591,600.00	161,979.00	2,429,621.00	ХУД-ийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс
15	Принтер самсунг 2070	2019.09.18	ш	1	309,980	309,980.00	38,747.50	271,232.50	ХУД-ийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс
16	Dell optiMex I5 суурин компьютер	2019.09.18	ш	3	1,854,930	5,564,790.00	463,732.50	5,101,057.50	ХУД дэх Цагдаагийн газар
17	Dell optiMex I3 суурин компьютер	2019.09.18	ш	3	1,295,800	3,887,400.00	161,980.00	3,725,420.00	ХУД дэх Цагдаагийн газар
18	Принтер самсунг 2070	2019.09.18	ш	2	309,980	619,960.00	77,495.00	542,465.00	ХУД дэх Цагдаагийн газар
19	Dell optiMex I3 суурин компьютер	2019.09.18	ш	2	1,295,800	2,591,600.00	323,950.00	2,267,650.00	ХУД дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс
20	Принтер самсунг 2070	2019.09.18	ш	1	309,980	309,980.00	38,747.50	271,232.50	ХУД дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс
21	Dell optiMex I3 суурин компьютер	2019.09.18	ш	1	1,295,800	1,295,800.00	161,977.00	1,133,823.00	ХУД-ийн Эрүүл мэндийн төв
22	Принтер самсунг 2070	2019.09.18	ш	1	309,980	309,980.00	38,747.50	271,232.50	ХУД-ийн Эрүүл мэндийн төв
<b>Нийт дүн</b>									
							<b>2,932,427.49</b>	<b>26,269,162.51</b>	

Хан-Уул  
дүүргийн  
Засаг  
даргын  
тамгын газар